

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ
/2024, 2025 оны 2 сарын байдлаар/

№	Үзүүлэлт		Нэгж	2024	2025	Өсөлт, бууралт
1	Төрсөн эх		Бодит тоо	197	186	11↓
2	Амьд төрсөн хүүхэд		Бодит тоо	198	191	7↓
3	Амьгүй төрсөн хүүхэд		Бодит тоо	0	0	0
			1000 нийт төрөлтөд	0.0	0.0	0.0
4	Гэрийн төрөлт		Бодит тоо	0	0	0.0
			Хувь	0.0	0.0	0.0
5	Хагалгаат төрөлт		Бодит тоо	33	51	18↑
			Хувь	16.8	27.4	10.6↑
6	Нас баралт		Бодит тоо	86	88	2↑
7	Эмнэлгийн нас баралт		Бодит тоо	14	16	2↑
			Хувь	16.2	18.2	2.0↑
8	Хоног болоогүй нас баралт		Бодит тоо	4	3	1↓
			Хувь	28.6	18.7	9.9↓
9	Эхийн эндэгдэл		Бодит тоо	1	0	1↓
			100000 амьд төрөлтөд	505.1	0.0	
10	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл		Бодит тоо	3	4	1↑
			1000 амьд төрөлтөд	15.1	21.0	5.9↑
11	0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл		Бодит тоо	2	2	0
			1000 амьд төрөлтөд	10.1	10.5	0.4↑
12	Нярайн эндэгдэл /0-29 хүртэлх хоног/		Бодит тоо	1	2	1↑
			1000 амьд төрөлтөд	5.0	10.5	5.5↑
			Нялхсын эндэгдэлд эзлэх хувь	50.0	100.0	50.0↑
	Үүнээс	Нярайн эрт үеийн эндэгдэл	Бодит тоо	1	2	1↑
			Хувь	100.0	100.0	0
		Нярайн хожуу үеийн эндэгдэл	Бодит тоо	0	0	0
			Хувь	0.0	0.0	0.0

13	Перинаталь эндэгдэл		Бодит тоо	1	2	1↑
			1000 нийт төрөлтөд	5.0	10.5	5.5↑
14	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл		Бодит тоо	1	2	1↑
			1000 амьд төрөлтөд	5.0	10.5	5.5↑
15	Шалтгаан	Өвчний улмаас	Бодит тоо	1	2	1↑
		Осол гэмтлээр	Бодит тоо	0	0	0
16	Эмчлэгдсэн өвчтөн		Бодит тоо	4456	4476	20↑
17	Орны фонд ашиглалт		Хувь	35.6	34.6	1.0↓
18	Ор хоног		Бодит тоо	31272	31025	247↓
19	Дундаж ор хоног		Бодит тоо	7.0	6.9	0.1↓
20	Орны эргэлт		Бодит тоо	5.1	5.0	0.1↓

**Бүртгэгдсэн халдварт өвчин
/2024,2025 оны 2 сарын байдлаар/**

№	Үзүүлэлт	Нэгж	2024	2025	Өсөлт, бууралт
	Халдварт өвчин-Бүгд	Бодит тоо	76	94	18↑
Үүнээс	Амьсгалын замын халдварт өвчин	Бодит тоо	33	45	12↑
	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин	Бодит тоо	35	41	6↑
	Гэдэсний халдварт өвчин	Бодит тоо	7	8	1↑
	Зоонозын халдварт өвчин	Бодит тоо	0	0	0
	Бусад халдварт өвчин	Бодит тоо	1	0	1↓
	Сальмонеллёз	Бодит тоо	1	4	3↑
Үүнээс	Цусан суулга	Бодит тоо	6	4	2↓
	Заг хүйтэн	Бодит тоо	6	16	10↑
	Трихомониаз	Бодит тоо	20	18	2↓
	Тэмбүү	Бодит тоо	9	7	2↓
	Үүнээс төрөлхийн тэмбүү				
	Сүрьеэ	Бодит тоо	15	13	2↓
	Салхин цэцэг	Бодит тоо	10	30	20↑
	Гахайн хавдар	Бодит тоо	1	0	1↓
	Гар хөл амны өвчин	Бодит тоо	2	1	1↓
	Ковид-19	Бодит тоо	4	0	4↓
	Хачигт халдвар	Бодит тоо	0	0	0
	Улаан эсэргэнэ	Бодит тоо	1	1	=
	Ёлом	Бодит тоо	1	0	1↓


ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

/2025 оны 2 сарын байдлаар/

Төрөлт

2025 оны эхний 2 сарын байдлаар аймгийн хэмжээнд 186 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 11 төрөлтөөр буюу 5.6% -иар буурсан байна.

График 1. Төрсөн эхийн тоо, сүүлийн 4 жилийн эхний 2 сарын байдлаар




Нийт төрөлтийн 3.2 хувийг өсвөр насны охидын төрөлт эзэлж байгаа ба өмнөх онтой харьцуулахад 2.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Гэрийн төрөлт, нийт төрөлтөд эзлэх хувиар, сумын байршлаар
Гэрийн төрөлт өмнөх он ба энэ онд бүртгэгдээгүй байна.

Хүүхдийн эрүүл мэнд

2025 оны 2 сарын байдлаар аймгийн хэмжээнд 191 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 7 хүүхдээр буюу 3.5 хувиар буурсан байна. Амьд төрсөн хүүхдийн 97 буюу 50.8 хувь нь хүү, 94 буюу 49.2 хувь нь охин байна. Амьд төрсөн хүүхдээс 5 ихэр төрөлт бүртгэгдсэн байна.

График 2. Амьд төрсөн хүүхдийн тоо үүнээс эмэгтэй, сүүлийн 4 жилийн 2 сарын байдлаар




Хүснэгт 2. Амьгүй төрөлт, 1000 нийт төрөлтөд, сумын байршлаар
Амьгүй төрөлтийн тохиолдол өмнөх он ба энэ онд бүртгэгдээгүй байна.

Жирэмсний хяналт

Жирэмсний хяналтад шинээр авсан эмэгтэйчүүд 219 хамрагдсаны эрт үе буюу эхний 3 сартайд 88.1 хувь, 4-6 сартайдаа 10.0 хувь, 7 ба түүнээс дээш сартайд 1.8 хувь нь тус тус хамрагдсан байна. Үүнээс цусны шинжилгээнд хамрагдалт 99.1 хувь үүнээс 0.5 хувь цус багадалттай байна.

График 3. Жирэмсний эрт хяналтын хувь, сумын байршлаар



Эмчийн хяналтгүй төрөлтийн тохиолдол өмнөх болон энэ онд бүртгэгдээгүй.

Эхийн эндэгдэл

2024 оны 2 сарын байдлаар эхийн эндэгдэл 1, 2025 оны 2 сарын байдлаар эхийн эндэгдэл бүртгэгдээгүй үзүүлэлттэй байна.

Нялхсын эндэгдэл

2025 оны 2 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгдэж, амьд төрсөн 1000 хүүхдэд 10.5 ногдож байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тохиолдлын тоо адил байгаа ба 1000 амьд төрөлтөд 0.4-өөр өссөн байна. Нялхсын эндэгдэл нь нярай үедээ буюу 0-28 хоногтойдоо эндсэн байна. Эрт нярайн эндэгдэл өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор их үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3. Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд

Эмнэлгийн нэр	2024 он	2025 он
АНЭ	9.6	9.6
МНЭ	0	12.2

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдол урд онд 3 бүртгэгдэж, энэ онд 4 тохиолдол бүртгэгдэж урд онтой харьцуулахад энэ онд 1 тохиолдлоор их, 1000 амьд төрөлтөд 5.5-аар өссөн байна.

Тав хүртэлх хүүхдийн эндэгдэл, шалтгаанаар:

Шалтгаан	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл			
	2024 он		2025 он	
	Бодит тоо	Эндэгдэлд харьцуулсан хувь	Бодит тоо	Эндэгдэлд харьцуулсан хувь
Шээс бэлгийн тогтолцооны эмгэг	1	33.3	0	0.0
Амьсгалын тогтолцооны эмгэг	1	33.3	2	50.0
Перинатал үед үүсэх зарим оёг	1	33.3	2	50.0
Нийт	3	100.0	4	100.0


АМБУЛАТОРИ, СТАЦИОНАРЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

2025 оны 2 сарын байдлаар нийт 96790 үзлэг хийгдэж өнгөрсөн оны мөн үеэс 4.6 хувиар 4426 үзлэгээр өссөн байна. Нийт үзлэгийн 22.0 хувь нь өрхийн эрүүл мэндийн төвд хийгдсэн байна. Нийт үзлэгийн 24.5 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 55.0 хувийг өвчний учир амбулатор, 8.6 хувийг диспансерийн хяналтын үзлэг, 11.0 хувийг гэрийн идэвхтэй хяналтын үзлэг, 0.9 хувийг гэрийн дуудлага тус тус эзэлж байна.

Хүснэгт 4. Эмчийн үзлэг, үзлэгийн төрлөөр, хувиар

[illegible]

График 4. Нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь, 2025 оны 2 сарын байдлаар



Стационарын тусламж үйлчилгээ

2025 оны 2 сарын байдлаар нийт 4476 хүн хэвтэн эмчлэгдэж 31025 ор хоног ашигласан бөгөөд ор ашиглалт 34.6, дундаж ор хоног 6.9, орны эргэлт 5.0 байна.

Эмнэлгийн нас баралтын 16 тохиолдол эмнэлгийн нас баралтын хувь 18.2 байна.

Хоног болоогүй 3 тохиолдол бүртгэгдэж эмнэлгийн нас баралтын 18.7 хувь, 8-24 цагийн дотор нас барсан 1 буюу 33.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт 5. Стационарын үзүүлэлтүүд

	Сум, эмнэлгийн нэр	Орны тоо	Ашигласан ор хоног	Эмчлэгдэж гарсан өвчтөн	Эмнэлэгт нас барсан	Орны фонд ашиглалт	Орны эргэлт	Дундаж ор хоног
1	Алтанбулаг	15	437	64	0	29.1	4.3	6.8
2	Баянгол	16	754	118	0	47.1	7.4	6.4
3	Баруунбүрэн	15	297	56	0	19.8	3.7	5.3
4	Ерөө	18	468	61	1	26.0	3.4	7.7
5	Бугант	15	334	52	0	22.3	3.5	6.4
6	Зүүнбүрэн	14	504	72	0	36.0	5.1	7.0
7	Түнхэл	15	497	76	0	33.1	5.1	6.5
8	Хэрх	16	633	85	0	39.6	5.3	7.4
9	Орхон	15	271	41	0	18.1	2.7	6.6

10	Орхонтуул	14	349	51	0	24.9	3.6	6.8
11	Шар-ус	12	407	60	0	33.9	5.0	6.8
12	Номгон	12	220	30	0	18.3	2.5	7.3
13	Сант	14	271	40	0	19.4	2.9	6.8
14	Түшиг	13	307	43	0	23.6	3.3	7.1
15	Шаамар	13	624	93	0	48.0	7.2	6.7
16	Дулаанхаан	12	212	32	1	17.7	2.7	6.6
17	Хүдэр	15	475	67	0	31.7	4.5	7.1
18	Жавхлант	13	561	87	0	43.2	6.7	6.4
19	Цагааннуур	19	663	106	0	34.9	5.6	6.3
20	Хушаат	14	352	46	0	25.1	3.3	7.7
21	Сайхан	62	1176	165	0	19.0	2.7	7.1
22	АНЭ	219	8302	1134	10	37.9	5.2	7.3
23	МСНЭ	187	7792	1110	4	41.7	5.9	7.0
24	Хувийн эмнэлэг	114	5119	787	0	44.9	6.9	6.5
25	Бусад эмнэлэг	24	0	0	0	0.0	0.0	0
	Бүгд дүн	896	31025	4476	16	34.6	5.0	6.9

Түргэн тусламжийн үзүүлэлт

2025 оны 2 сарын байдлаар нийт 4300 дуудлага хүлээн авч үйлчилснээс 143 буюу 3.3 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байна. Нийт дуудлага өмнөх оноос 366-аар буурч, осол гэмтлийн дуудлага 9-өөр өссөн байна.


Нас баралт

2025 оны 2 сарын байдлаар 88 нас баралтын тохиолдол бүртгэгдсэн байна. 88 тохиолдол бүртгэгдсэний 55.7 хувь нь эрэгтэй, 44.3 хувь нь эмэгтэйчүүд байна. Нас баралтыг шалтгаанаар авч үзэхэд хорт хавдрын нас баралт 25.0, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 13.6 хувийг тус тус эзэлж байна.

ХАЛДВАРТ ӨВЧИН

2025 оны эхний 2 сарын байдлаар халдварт өвчний 94 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 8.5 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18 тохиолдлоор, 10000 хүн амд 1.8-аар тус тус нэмэгдсэн байна.

График 5. Бүртгэгдсэн халдварт өвчин, 10000 хүн амд, сумын байршлаар




Амьсгалын замаар дамжих халдварт өвчин өнгөрсөн оны мөн үеэс 10000 хүн амд 0.4-өөр өссөн, бусад халдварт өвчин 0.1-ээр буурсан ба бэлгийн замаар

дамжих халдварт өвчин 0.5-аар, гэдэсний халдварт өвчин 0.2-оор тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Амьсгалын замын халдварт өвчин

Амьсгалын замын цочмог халдварт өвчин нийт 45 бүртгэгдсэн нь халдварт өвчний 47.8 хувийг эзэлж, 10000 хүн амд 4.1 байна. Нийт амьсгалын замын өвчлөлийн 66.6 хувийг салхинцэцэг, 28.8 хувийг сүрьеэ, 2.3 хувийг улаан эсэргэнэ, 2.3 хувийг гар, хөл, амны өвчин тус тус эзэлж байна.

График 6. Амьсгалын замын зарим халдварт өвчин, 10000 хүн амд, сүүлийн 4 жилээр




Шинээр илэрсэн сүрьеэгийн 13 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 1.2 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 тохиолдлоор буурсан байна. Нийт тохиолдлын 7.7 хувийг 0-14 насны хүүхэд эзэлж байна.

Салхинцэцэгийн халдварын 30 тохиолдол бүртгэгдсэн ба 10000 хүн амд 2.7 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 тохиолдлоор өссөн ба өвчлөлийн 33.3 хувийг 0-4 насныхан эзэлж байна.

Бэлгийн замаар дамжих халдвар

Зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдварын 41 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 43.6 хувийг эзэлж байна. Нийт бэлгийн замаар дамжих халдварын 39.0 хувийг заг хүйтэн, 17.0 хувийг тэмбүү, 43.9 хувийг трихомониаз, тус тус эзэлж байна. Нийт өвчлөлийн 19.5 хувийг 10-19 насныхан эзэлж байгаа нь өмнөх оноос 11.9 хувиар буурсан.

График 7. Зонхилон тохиолдох БЗДХ, 10000 хүн амд, 2024, 2025 оны эхний 2 сарын байдлаар



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Хянасан: Т.Болормаа /ХШҮМХ-ийн мэргэжилтэн/

Мэдээллийг бэлтгэсэн: Б.Батцэцэг /ХШҮМХ-ийн мэргэжилтэн/